

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дуурь бүжгийн эрдмийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/82/НА-СТА-ТШЗ

| | |
|--|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p> | <p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsege@audit.gov.mn</p> <p>Аудитор: С.Билгүтэй Утас: 261628 Цахим хаяг: bilguteis@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p> |
|--|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 6 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... | 6 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 8 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 10 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... | 12 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 13 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан | 15 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 16 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 16 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..... | 16 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 17 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд | 17 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 18 |
| 3.5.1 Төсвийн төлөвлөлт | 18 |
| 3.5.2 Төсвийн гүйцэтгэл | 18 |
| 3.5.3 Нэмэлт төсөв | 19 |
| 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл | 20 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 21 |
| 4.1 Ерөнхий зүйл | 21 |
| 4.2 Материаллаг байдал..... | 21 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт..... | 21 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 21 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 22 |
| 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд..... | 22 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 24 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 24 |
| 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн..... | 24 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 24 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 25 |
| 5.1 Төлбөрийн акт..... | 25 |
| 5.2 Албан шаардлага | 26 |
| 5.3 Зөвлөмж..... | 28 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 29 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---------------|--|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| СБТ | Санхүүгийн байдлын тайлан |
| САГ | Санхүүгийн аудитын газар |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/409
танай _____-ны № _____-т

ДУУРЬ БҮЖГИЙН ЭРДМИЙН
ТЕАТРЫН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭНХЖАРГАЛ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 222,505.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

1. Тайланд 138,188.7 мянган төгрөгийн авлага, 19,722.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
2. Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх тушаал гарсан ч, аудитад жилийн эцсийн тооллогын бүртгэл ирүүлээгүй;
3. Тайз түрээс, тоглолт хамтран зохион байгуулах гэрээний үлдэгдэл төлбөр 38,000.0 мянган төгрөгийн авлагаар тайлагнаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
4. Үзвэрийн тасалбарыг хэвлэмэл дугааргүй, үнийн ангилалгүй, тасалбар хэвлэсэн компанитай хүлээн авсан акт үйлдээгүй, кассын орлогыг хувийн дансаар хүлээн авч тухай бүр төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлээгүйгээс 7,457.0 мянган төгрөгийн тасалбарын тооцоо зөрүүтэй, 735.0 мянган төгрөгийн тасалбарын орлогыг төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй;

5. Ажиллагсдын цалингийн тооцоололд хууль тогтоомж мөрдөөгүйгээс 5,502.0 мянган төгрөгийн илүү цалин олгосон;
6. Цайны газрын барилгыг иргэнд түрээсэлсэн гэрээг эрх бүхий байгууллагаар батлуулаагүй, гэрээний дүнгийн 40.0 хувь буюу 8,400.0 мянган төгрөг, түрээсийн гэрээний төлбөрийн дутуу 4,500.0 мянган төгрөгийг авлагаар тайлагнаагүй, төсөвт нийт 12,900.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй зэрэг зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1, 72.4.1-д “Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, тохиолдсон байх, үнэн ба зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Дуурь бүжгийн эрдмийн театр нь П.И.Чайковский “Хунт нуур” балетыг анх толилуулсны 50 жилийн ойн хүрээнд Захирлын 2025 оны А/34, А/33 дугаар тушаалаар Балетын хуучин тавилтыг толилуулахад 45,964.0 мянган төгрөг, ОХУ-ын Буриадын дуурь, балетын академик театрын уран бүтээлчдийн тоглолтод 99,607.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны жилийн эцсийн тооллого хийх тухай Захирлын 2025 оны А/83 дугаар тушаал гаргасан боловч аудит хийх хугацаанд санхүүгийн тайланд тайлагнасан 5,792,938.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,638,652.5 мянган төгрөгийн бараа материалын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бүртгэл ирүүлээгүй болно.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын тушаалаар 3 удаа ажлаас чөлөөлж, сонгон шалгаруулалтгүй түр хугацаагаар томилсон. Мөн театрын захирлын тушаалаар Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогчийг 4 удаа ажлаас чөлөөлж, томилсноос санхүү бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаагүй, албан тушаалтны үүрэг хариуцлагын тогтолцоо сул, дотоод хяналтын орчин хангалтгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б. А. Д. НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|------------------------------------|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,752,961,370.37 | 1,776,841,148.88 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4,650,000.00 | - |
| 31100 | Кассанд байгаа бэлэн мөнгө | 991.18 | - |
| 31110 | Төгрөг | 991.18 | - |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 4,649,008.82 | - |
| 31210 | Төгрөг | 4,649,008.82 | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 4,649,008.82 | - |
| 33 | АВЛАГА | 52,278,012.29 | 114,788,677.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 68,886.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 68,674,800.00 |
| 33500 | Бусад авлага | 52,278,012.29 | 46,044,991.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 52,278,012.29 | 46,044,991.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 60,730,000.00 | 23,400,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 60,730,000.00 | 23,400,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,635,303,358.08 | 1,638,652,471.88 |
| 35100 | Түүхий эд материал | 2,939,779.98 | 3,018,674.98 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 2,939,779.98 | 2,706,174.98 |
| 35130 | Эм боох материал | - | 312,500.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | 3,070,360.00 | 9,791,265.00 |
| 35400 | Хангамжийн материал | 1,619,293,218.10 | 1,625,842,531.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 145,000.00 | 636,760.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 117,228,009.80 | 123,398,563.60 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,501,920,208.30 | 1,501,807,208.30 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,527,431,606.17 | 2,223,855,660.74 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,527,431,606.17 | 2,223,855,660.74 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,262,565,961.17 | 1,958,990,015.74 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,141,338,957.19 | 3,141,338,957.19 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,256,005,766.01) | (1,464,929,313.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 116,920,000.00 | 116,920,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (102,520,000.22) | (105,720,000.26) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,510,678,663.43 | 1,531,079,663.43 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,324,682,974.35) | (1,398,369,055.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 369,144,580.66 | 369,144,580.66 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (249,431,703.60) | (280,823,459.27) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 12,715,000.00 | 12,715,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 351,149,730.00 | 351,149,730.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (306,740,525.93) | (313,516,087.00) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 264,865,645.00 | 264,865,645.00 |
| 39301 | Програм хангамж | 60,225,000.00 | 60,225,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,725,000.00) | (5,725,000.00) |

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------------|--|-------------------------|-------------------------|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 210,365,645.00 | 210,365,645.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 4,280,392,976.54 | 4,000,696,809.62 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 19,722,582.72 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 19,722,582.72 |
| 41300 | Өглөг | - | 19,722,582.72 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 3,432,582.72 |
| 41360 | Бусад өглөг | - | 16,290,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 14,790,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,500,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,280,392,976.54 | 3,980,974,226.90 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,280,392,976.54 | 3,980,974,226.90 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,684,145,237.49 | 1,684,145,237.49 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 1,684,145,237.49 | 1,684,145,237.49 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | (1,270,403,896.23) | (1,569,822,645.87) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,423,376,295.32) | (1,270,403,896.23) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 152,972,399.09 | (299,418,749.64) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,866,651,635.28 | 3,866,651,635.28 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 4,280,392,976.54 | 4,000,696,809.62 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 10,928,312,300.00 | 10,715,126,700.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 3,120,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 3,120,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | - | 3,120,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 10,712,006,700.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 10,712,006,700.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 8,923,270,000.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 8,923,270,000.00 |
| 122134 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,000,000.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,786,736,700.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,928,312,300.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 8,683,607,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 8,683,607,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,244,704,500.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 788,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,456,704,500.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 10,775,339,900.91 | 11,014,545,449.64 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,775,339,900.91 | 11,014,545,449.64 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,848,831,393.94 | 9,791,226,273.01 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,101,541,034.59 | 7,510,172,878.70 |
| 210101 | Үндсэн цалин | 4,351,753,697.94 | 4,850,983,556.29 |
| 210102 | Нэмэгдэл | 949,150,646.65 | 853,477,892.41 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,175,925,000.00 | 1,285,583,000.00 |
| 210104 | Урамшуулал | 624,711,690.00 | 520,128,430.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 876,598,830.02 | 929,752,288.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 602,641,780.91 | 635,471,124.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 69,651,468.82 | 75,298,948.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 40,353,708.51 | 45,443,477.33 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 32,329,638.98 | 34,129,054.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 131,622,232.80 | 139,409,683.54 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 119,341,461.59 | 142,456,029.11 |

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|--|-----------------------|-------------------------|
| 210301 | Гэрэл цахилгаан | 55,725,706.78 | 82,871,923.20 |
| 210302 | Түлш, халаалт | 52,970,064.54 | 48,957,840.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,645,690.27 | 10,626,265.80 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 339,626,673.31 | 97,368,056.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,079,100.00 | 9,526,040.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 5,737,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,628,506.80 | 3,719,115.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,832,000.00 | 2,016,000.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 231,711,181.51 | 76,369,901.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 92,375,885.00 | - |
| 2105 | Норматив зардал | - | 2,569,935.29 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 2,569,935.29 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 247,329,750.00 | 62,146,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 354,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 247,329,750.00 | 61,792,700.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,790,000.00 | 5,832,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 5,832,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,790,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 831,657,951.38 | 716,951,440.04 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 827,859,891.38 | 715,169,688.04 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,400,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 153,600.00 | 502,692.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,244,460.00 | 1,246,060.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 317,945,693.05 | 323,976,945.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,500.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 317,936,193.05 | 323,976,945.43 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 926,508,506.97 | 1,223,319,176.63 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 726,381,757.61 | 152,539,068.31 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 47,841,300.00 | 42,500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 145,340,757.61 | 110,039,068.31 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 533,199,700.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 200,126,749.36 | 1,070,780,108.32 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 145,675,781.23 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 54,450,968.13 | - |
| 2135 | Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 1,070,780,108.32 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,070,780,108.32 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 152,972,399.09 | (299,418,749.64) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 152,972,399.09 | (299,418,749.64) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|--------------|---|--------------------------|--------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 10,955,640,300.00 | 10,623,154,102.87 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 10,623,154,102.87 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 2,830,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 2,830,000.00 |
| 12 | ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | - | 10,620,324,102.87 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 10,620,324,102.87 |
| 12211 | Харьяа төрийн сангаас төрийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 8,923,270,000.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 8,923,270,000.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 1,697,054,102.87 |
| 122134 | Төсвөөс доод шатны захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 2,000,000.00 |
| 122135 | Төсвийн байгууллагын хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 1,695,054,102.87 |
| 130 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,955,640,300.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 8,683,607,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 8,683,607,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,272,032,500.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | 788,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,484,032,500.00 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 10,777,163,390.00 | 10,610,237,102.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 10,777,163,390.00 | 10,610,237,102.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,850,154,883.03 | 9,368,395,926.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,119,822,717.01 | 7,487,423,899.13 |
| 210101 | Үндсэн цалин | 4,487,676,132.35 | 4,755,949,393.66 |
| 210102 | Нэмэгдэл | 828,362,431.19 | 907,457,469.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,174,629,418.70 | 1,295,498,033.60 |
| 210104 | Урамшуулал | 629,154,734.77 | 528,519,002.03 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 889,384,757.97 | 943,646,550.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 610,391,488.70 | 643,170,850.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 70,137,882.41 | 75,146,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 39,599,488.46 | 39,618,536.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 33,592,442.07 | 35,740,163.01 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 135,663,456.33 | 149,970,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 119,341,461.59 | 142,456,029.11 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 55,725,706.78 | 76,085,511.64 |
| 210302 | Түлш, халаалт | 52,970,064.54 | 56,641,402.55 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,645,690.27 | 9,729,114.92 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,606,466.80 | 82,597,369.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,195,050.00 | 10,729,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 600,000.00 | 5,500,000.00 |

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|-------------------------|-------------------------|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,628,506.80 | 3,719,115.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгдийн устгал, ариутгал | 4,032,000.00 | 2,016,000.00 |
| 210406 | Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 31,150,910.00 | 60,632,654.00 |
| 2105 | Норматив зардал | 7,000,000.00 | 1,575,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,000,000.00 | 1,575,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 277,037,580.00 | 112,507,910.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,535,700.00 | 11,360,500.00 |
| 210602 | Тавилга | 7,663,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 261,838,080.00 | 101,147,410.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,105,851.00 | 5,832,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 5,832,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,105,851.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,375,780,298.66 | 592,357,169.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,366,982,238.66 | 590,575,417.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 5,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,400,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 153,600.00 | 535,692.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,244,460.00 | 1,246,060.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,075,750.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал. | 2,075,750.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 927,008,506.97 | 1,241,841,176.63 |
| 21311 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 1,062,780,108.32 |
| 213111 | Төрийн сангаас харъяа төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн зардал | - | 4,650,000.00 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | - | 1,058,130,108.32 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 726,881,757.61 | 179,061,068.31 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 47,841,300.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 145,340,757.61 | 110,039,068.31 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 533,699,700.00 | 69,022,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 200,126,749.36 | - |
| 213303 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 145,675,781.23 | - |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 54,450,968.13 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 173,476,909.82 | 12,917,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН | 173,826,910.00 | 17,567,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 173,826,910.00 | 17,567,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 173,826,910.00 | 17,567,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (173,826,910.00) | (17,567,000.00) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (350,000.18) | (4,650,000.00) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 4,650,000.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,650,000.00 | - |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|------------|---|---------------------------------|-------------------------|---------------------------|--|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,684,145,237.49 | 3,866,368,735.28 | (1,423,376,295.32) | 4,127,137,677.45 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | 282,900.00 | - | 282,900.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,684,145,237.49 | 3,866,651,635.28 | (1,423,376,295.32) | 4,127,420,577.45 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 152,972,399.09 | 152,972,399.09 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,684,145,237.49 | 3,866,651,635.28 | (1,270,403,896.23) | 4,280,392,976.54 |
| 11 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,684,145,237.49 | 3,866,651,635.28 | (1,270,403,896.23) | 4,280,392,976.54 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (299,418,749.64) | (299,418,749.64) |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,684,145,237.49 | 3,866,651,635.28 | (1,569,822,645.87) | 3,980,974,226.90 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------------|---|-------------------------|-------------------------|-----------------------|---------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 9,143,687,800.00 | 8,926,100,000.00 | 217,587,800.00 | 97.62 |
| 122 | ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 9,143,687,800.00 | 8,923,270,000.00 | 220,417,800.00 | 97.59 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 9,143,687,800.00 | 8,923,270,000.00 | 220,417,800.00 | 97.59 |
| 120 | НИЙТЛЭГ ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 2,830,000.00 | (2,830,000.00) | 100.00 |
| 120009 | Бусад орлого | - | 2,830,000.00 | (2,830,000.00) | 100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,143,687,800.00 | 8,754,032,412.42 | 389,655,387.58 | 95.74 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 9,143,687,800.00 | 8,754,032,412.42 | 389,655,387.58 | 95.74 |
| 210 | БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 8,926,773,900.00 | 8,643,993,344.11 | 282,780,555.89 | 96.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,550,492,600.00 | 7,479,779,800.00 | 70,712,800.00 | 99.06 |
| 210101 | Үндсэн цалин | 4,765,036,900.00 | 4,755,949,393.66 | 9,087,506.34 | 99.81 |
| 210102 | Нэмэгдэл | 1,120,127,900.00 | 907,457,469.84 | 212,670,430.16 | 81.01 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,073,812,900.00 | 1,295,498,033.60 | (221,685,133.60) | 120.64 |
| 210104 | Урамшуулал | 591,514,900.00 | 520,874,902.90 | 70,639,997.10 | 88.06 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 943,686,000.00 | 943,646,550.00 | 39,450.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 643,210,300.00 | 643,170,850.00 | 39,450.00 | 99.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 75,146,200.00 | 75,146,200.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 37,886,700.00 | 39,618,536.99 | (1,731,836.99) | 104.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 37,472,000.00 | 35,740,163.01 | 1,731,836.99 | 95.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 149,970,800.00 | 149,970,800.00 | - | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 146,625,100.00 | 142,456,029.11 | 4,169,070.89 | 97.16 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 84,652,200.00 | 76,085,511.64 | 8,566,688.36 | 89.88 |
| 210302 | Түлш, халаалт | 52,035,200.00 | 56,641,402.55 | (4,606,202.55) | 108.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,937,700.00 | 9,729,114.92 | 208,585.08 | 97.90 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,059,100.00 | 32,501,095.00 | (6,441,995.00) | 124.72 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,196,100.00 | 787,800.00 | 408,300.00 | 65.86 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,990,400.00 | 1,736,515.00 | 1,253,885.00 | 58.07 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,077,500.00 | 450,000.00 | 627,500.00 | 41.76 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 20,795,100.00 | 29,526,780.00 | (8,731,680.00) | 141.99 |
| 2105 | Норматив зардал | 6,278,400.00 | 1,575,000.00 | 4,703,400.00 | 25.09 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,278,400.00 | 1,575,000.00 | 4,703,400.00 | 25.09 |

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|--------|--|-----------------------|-----------------------|-----------------------|--------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 107,199,900.00 | - | 107,199,900.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 107,199,900.00 | - | 107,199,900.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 66,032,900.00 | 44,034,870.00 | 21,998,030.00 | 66.69 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 57,451,200.00 | 42,601,610.00 | 14,849,590.00 | 74.15 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 4,977,100.00 | - | 4,977,100.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 2,150,100.00 | - | 2,150,100.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 208,800.00 | 187,200.00 | 21,600.00 | 89.66 |
| 210807 | Газрын төлбөр | 1,245,700.00 | 1,246,060.00 | (360.00) | 100.03 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,399,900.00 | - | 80,399,900.00 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,399,900.00 | - | 80,399,900.00 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 216,913,900.00 | 110,039,068.31 | 106,874,831.69 | 50.73 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 216,913,900.00 | 110,039,068.31 | 106,874,831.69 | 50.73 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 40,200,000.00 | - | 40,200,000.00 | - |
| 213207 | Тэтгэварт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 176,714,000.00 | 110,039,068.31 | 66,674,931.69 | 62.30 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | - | 172,067,587.58 | (172,067,587.58) | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 523 | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 285 | 285 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 226 | 226 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 57 | 57 | - | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Тайлант он |
|------------|--|-------------------------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,697,054,102.87 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,697,054,102.87 |
| 122 | Тусламжийн орлого | 1,697,054,102.87 |
| 350014 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,695,054,102.87 |
| 350015 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 810,991,582.13 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 810,991,582.13 |
| 210 | БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 741,969,582.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 7,644,099.13 |
| 210104 | Урамшуулал | 7,644,099.13 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 50,096,274.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,941,800.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 5,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,982,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,566,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 31,105,874.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 130,074,910.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 28,927,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 101,147,410.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,832,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 5,832,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 548,322,299.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 547,973,807.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 348,492.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 69,022,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 69,022,000.00 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 886,062,520.74 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (886,062,520.74) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (886,062,520.74) |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дуурь бүжгийн эрдмийн театр нь хөгжмийн болон тайзны урлагийн бүтээл туурвих, толилуулах, түгээн дэлгэрүүлэх үндсэн үйл ажиллагаа бүхий соёл урлагийн үйлчилгээний төрийн өмчит, мэргэжлийн дуурь бүжгийн үндэсний театр юм.

Эрхэм зорилго: Театрын хөгжлийн залгамж холбоог шинэчлэн, бодлогын стратегийг тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулан, сонгодог урлагийг эрхэмлэн, соёлт нийгэмд хүртээмжтэй түгээнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, Соёлын сайдын 2023 оны “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”

Дуурь бүжгийн эрдмийн театрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант онд дотоод хяналтын ажилтан 2 удаа солигдсон. Театрын захирлын тушаалаар томилогдсон Дотоод хяналт шалгалтын баг 2025 оны 1-4 дүгээр сард олгосон цалин хөлс, нэмэгдэл урамшуулалд хяналт шалгалт хийж, 6,084.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэн ч цалингийн нягтлан бодогч солигдсонтой холбоотой зөрчлийг арилгаагүй.

Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/68 дугаар тушаалаар Дотоод хяналт шалгалт хийх удирдамж, төлөвлөгөө баталсан. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлангүй, дотоод хяналт бодитой хэрэгжээгүй, баримтжуулалт хангалтгүй байна.

Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс тайлант онд Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2025 он 3 дугаар сарын 21-ний өдрийн 05/5480 дугаар албан бичгийн дагуу 2025 оны 4 дүгээр сард, тус байгууллагын ажилчдын гаргасан гомдлын дагуу 2025 оны 9 дүгээр сард тус тус шалгалт хийсэн байна. Шалгалтын зөвлөмжийн биелэлтийн тайлан ирүүлээгүй.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартын шинэчлэл өөрчлөлтийг тусгаагүй байна.

Энэ хугацаанд санхүүгийн ажилтнууд ойр ойрхон солигдсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг баримтлаагүй, бүртгэлийн дотоод хяналт сул, байгууллагын онцлог бүртгэл үзвэрийн тасалбар, уран бүтээлийн хөрөнгө, урын сангийн бүртгэлүүдийг зөв ангилаагүй, зориулалтын дагуу бүртгээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 279,696.2 мянган төгрөгөөр буюу 6.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|--------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 4,650.0 | - | (4,650.0) |
| Авлага | - | 68,743.7 | 68,743.7 |
| Бусад авлага | 52,278.0 | 46,045.0 | (6,233.0) |
| Урьдчилж гарсан зардал | 60,730.0 | 23,400.0 | (37,330.0) |
| Бараа материал | 1,635,303.4 | 1,638,652.5 | 3,349.1 |
| Үндсэн хөрөнгө | 2,262,566.0 | 1,958,990.0 | (303,576.0) |
| Биет бус хөрөнгө | 264,865.6 | 264,865.6 | - |
| Нийт хөрөнгө | 4,280,393.0 | 4,000,696.8 | (279,696.2) |
| Богино хугацаат ер төлбөр | - | 19,722.6 | 19,722.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,684,145.2 | 1,684,145.2 | - |
| Хуримтлагдсан үр дүн | (1,270,403.8) | (1,569,822.6) | (299,418.8) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,866,651.6 | 3,866,651.6 | - |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 4,280,393.0 | 4,000,696.8 | (279,696.2) |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн дансдууд байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 68,743.7 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Гэр медиа ХХК-иас авах төлбөртэй үйлчилгээний авлага 68,674.8 мянган төгрөг, ажилчидтай холбогдсон авлага 68.9 мянган төгрөг байна;

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,958,990.0 мянган төгрөг болж 303,576.0 мянган төгрөгөөр буурсан нь ССАЖЗЯ-наас үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,120.0 мянган төгрөгийн компьютер, өөрийн үйл ажиллагааны орлогоор 17,281.0 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж худалдан авсан, тайлант оны элэгдлийн зардал 323,977.0 мянган төгрөгөөр буурсанаас шалтгаалсан;
- Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн тайлант оны үр дүн 279,696.2 мянган төгрөгөөр буурсан.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ACOLOUS санхүүгийн программ ашигладаг. Тус программын мэдээллийн баазыг нэмэгдүүлээгүйгээс ажил гүйлгээ устгах эрсдэлтэй, шинэчлэгдсэн хувилбарыг татан авч, хууль тогтоомжийн шинэчлэлт өөрчлөлтийг тусгах, мэдээллийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 11,819,714.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсний зардал 765,462.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 95,682.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11,110.5 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 28,310.0 мянган төгрөг, нормативт зардлыг 89,180.0 мянган төгрөг, эд хогшил, бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,030,337.7 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 410,663.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 9,411,189.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант жилийн дундуур тодотгол хийж, төсвийг 267,500.8 мянган төгрөгөөр бууруулж, 9,143,688.3 мянган төгрөгөөр баталсан байна.

ССАЖЗС-ын 2025 оны А/212 дугаар тушаалаар соёлын байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийг 267,999.7 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 40,200.2 мянган төгрөг олгосон. Дуурь бүжгийн эрдмийн театрын захирлын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/511 дугаар урамшуулалт цалинд 35,500.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 4,427.3 мянган төгрөгийг зарцуулж, 272.9 мянган төгрөгийг төрийн санд буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг 9,143,687.3 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 8,926,100.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 8,754,032.4 мянган төгрөгийг зарцуулж, 172,067.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,754,032.4 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 70,479.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 4,169.1 мянган төгрөг, нормативт зардлыг 5,409.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 14,849.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэгийн зардлын төсвөөс тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлыг 66,674.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|--------------------|--------------------|------------------|-------------|
| 1 | 71702-Соёл урлагийн хөтөлбөр | 9,143,687.8 | 8,754,032.4 | 389,655.4 | 95.7 |
| 1.1 | 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 8,641,523.0 | 8,561,464.4 | 80,058.6 | 99.1 |
| 1.2 | 80219- Харуул хамгаалалтын зардал | 57,451.2 | 42,601.6 | 14,849.6 | 74.2 |
| 1.3 | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 176,713.9 | 110,039.1 | 66,674.8 | 62.3 |
| 1.4 | 81855-Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт | 267,999.7 | 39,927.3 | 228,072.4 | 14.9 |

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

1. Байгууллагын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарчим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулах арга хэмжээний хүрээнд батлагдсан орон тоог бууруулж ажиллаагүй байна;
2. Театрын захирлын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/66 дугаар тушаалаар ажилтнуудын унааны нэмэгдлийг өдөрт 1,000 төгрөг, хоолны нэмэгдлийг 20,000 төгрөгөөр тооцож олгохоор баталсныг мөрдсөн. Захирлын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/82 дугаар тушаалаар унааны нэмэгдлийг өдөрт 3,000 төгрөг, хоолны нэмэгдлийг 32,000 төгрөг байхаар шинэчлэн баталсан. Тайлант онд унаа болон бусад нөхөн олговорт 1,073,812.9 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,295,498.0 мянган төгрөг зарцуулсан байна;
3. Тайлант онд гадаад томилолтын зардал 5,832.0 мянган төгрөг тайлагнасан, арга хэмжээний зардал гараагүй. Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар Монгол улс, Бүгд найрамдах Солонгос улсын дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойн хүрээнд Сөүл хотод зохион байгуулагдах “Нэг дэлхий цуурай” хүндэтгэлийн тоглолтонд оролцох уран бүтээлчдийн нэрс, зардлын төсөв, ажлын хуваарийг баталсан. Гадаад албан томилолтын зардлыг өөрийн үйл ажиллагааны орлогоос зарцуулсан байна;

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас 2,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,695,054.1 мянган төгрөг, нийт 1,697,054.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс тайлант оны цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 7,644.1 мянган төгрөг, хангамж, бараа материалд 50,096.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 130,074.9 мянган төгрөг, томилолт зочны зардалд 5,832.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 548,322.3 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 69,022.0 мянган төгрөгийг зарцуулж, 890,712.5 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчид буцаан төвлөрүүлсэн байна.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй. Хууль тогтоомжид нийцүүлэн тендер зарлаагүй, үнийн харьцуулсан судалгаа хийгээгүй нийт 54 аж ахуй нэгж, иргэнтэй 527,948.6 мянган төгрөгийн шууд худалдан авалтын гэрээ байгуулсан байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

| № | Худалдан авалт | Төлөвлөгөөний | | Гүйцэтгэлийн | | | Зөрүү | |
|------------|---------------------|---------------|------------|--------------|------------------|------|-------------|--------------------|
| | | Тоо | Мөнгөн дүн | Тоо | Мөнгөн дүн | Хувь | Тоо | Мөнгөн дүн |
| 1 | Шууд худалдан авалт | - | - | 54 | 527,948.6 | - | (54) | (527,948.6) |
| Дүн | | - | - | 54 | 527,948.6 | - | (54) | (527,948.6) |

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын дотооддоо баталж мөрддөг дүрэм, журмуудыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хооронд нь уялдаатай боловсруулан сайжруулах, Театрын үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн практик үйл ажиллагааны зааврыг өөрсдөө боловсруулан батлуулж мөрдөх талаар өгсөн нийцлийн асуудлын зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Э.Цэрэннадмид гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Билгүтэй, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дуурь бүжгийн эрдмийн театр нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 17 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тайлант оны батлагдсан төсвийн дүн 9,143,688.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 91,436.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дуурь бүжгийн эрдмийн театр нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлсийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 болон 15 дугаар зүйлийн 15.1.1 - 15.1.8 дахь заалтуудад заасан хуулиар хориглох зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 527,948.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 23 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 165 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал /Гүйцэтгэл/, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл–Хөтөлбөр, зориулалт /Гүйцэтгэл/ зэрэг 2 мэдээг хугацаа хоцроон байршуулсан.

Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын ажил гүйлгээнд 1 удаагийн 8,591.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн хаяг талбарт 11 удаагийн 43,200.0 мянган төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт талбарт бүтцийн задаргааг оруулаагүй 1-4 сардуудад "оруулах мэдээлэл байхгүй" гэж мэдээлсэн, тайлант хугацаанд байгууллагын дарга нь иргэн хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой "Ашиг сонирхлын мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй, тайлант онд хөрөнгө мөнгө захиран зарцуулсан 3 удаагийн 47,595.0 мянган төгрөгийн тушаал, гэрээг мэдээлээгүй, мэдээллийн хэрэгжилт 83.1 хувьтай байна. Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Худалдан авах ажиллагааны хуулийн хэрэгжилт:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан байхгүй. Тендер зарлаагүй, гэрээ байгуулахдаа харьцуулсан үнийн судалгаа шинжилгээ хийлгүй, нийт 54 аж ахуй нэгж, иргэнтэй 527,948.6 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс гэрээ дүгнэсэн актгүй 46,824.0 мянган төгрөгийн 8 гэрээ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 46 дугаар зүйлийн 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн

захирагчид цахим системээр тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй, тендер зарлаагүй шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт:

Дуурь бүжгийн эрдмийн театр нь Захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрддөг. Өнгөрсөн хугацаанд холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусган сайжруулаагүй, санхүүгийн ажилтнууд ойр ойрхон солигдсонтой холбоотой бүртгэлийн дотоод хяналт сул байна. Театрын онцлог бүртгэл үзвэрийн тасалбар, уран бүтээлийн хөрөнгө, урын сангийн бүртгэлүүдийг зөв ангилаагүй, зориулалтын дагуу бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Театрын үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн практик үйл ажиллагааны зааврыг төсвөөс хөрөнгө зарцуулахгүй, өөрсдөө шинэчлэн сайжруулж, мөрдөх зөвлөмж өгсөн

3. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт:

Дуурь бүжгийн эрдмийн театр нь нийт батлагдсан орон тоо 285, үүнээс тайлант жилд сул орон тоо 13 байна. Сул орон тоог тооцож Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасны дагуу 9 хувийн цомхотгол зохион байгуулаагүй. Зарим ажиллагсдын цалин хөлсийг тогтоохдоо төрийн үйлчилгээний ажилтнуудын цалингийн сүлжээнд нийцүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын бодлого чиглэлийг мөрдөж ажиллах, цаашид ажиллагсдын цалинг төрийн үйлчилгээний ажилтнуудын цалингийн сүлжээнд нийцүүлэх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан худалдан авах ажиллагааны хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, бүтэц орон тоог оновчтой төлөвлөж батлах нь холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2-р улирлын санхүүгийн тайланг хамруулж, горим сорил хэрэгжүүлж, нийт 594,096.9 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснийг шалгагдагч байгууллагад асуудлын бүртгэлээр танилцуулж, баталгаажуулсан.

Жилийн эцсийн аудитаар биелэлтийг шалгаж, хэрэгжээгүй 312,893.3 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 281,203.4 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 1 зөрчлийг дараагийн аудитаар анхаарах асуудалд оруулахаар төлөвлөсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 435,613.6 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс 19,610.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 192,755.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 129,148.4 мянган төгрөгийн зөрчилд 1 хариуцлага тооцох албан шаардлага, 94,100.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлснээс хэрэгжилтийн биелэлт 79.0 хувь байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Дд | Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|-----------------------------------|------------------------|------------------|----------|------------------|-------------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| 1 | Акт | 3 | 19,610.0 | 3 | 19,610.0 | 100.0 |
| 2 | Албан шаардлага | 2 | 192,755.2 | 1 | 151,852.5 | 79.0 |
| 3 | Хариуцлага тооцох албан шаардлага | 1 | 129,148.4 | 1 | 107,193.1 | 83.0 |
| 4 | Зөвлөмж | 1 | 94,100.0 | 1 | 65,870.0 | 70.0 |
| Нийт дүн | | 7 | 435,613.6 | 3 | 344,525.6 | 79.0 |

/мянган төгрөгөөр/

Худалдан авах ажиллагаатай холбоотой болон шилэн дансны цахим системд тавих мэдээллийн хугацааг хоцроосон, мэдээлээгүй өмнөх аудитын зөрчлүүд арилаагүй тул албан шаардлага хүргүүлсэн. Мөн төрд учирсан хохиролтой холбоотой албан шаардлага хэрэгжээгүй тул дараагийн аудитаар анхаарах асуудалд оруулж дээд шатны төсвийн захирагчийн анхааралд хандуулахаар төлөвлөсөн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны төсөв захирагч нь дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

- Өмнөх аудитаар шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтанд байгууллагаас олгосон 14,105.2 мянган төгрөгийн нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар төлүүлэх албан шаардлагыг ССАЖЗЯ-ны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, театрын захирал, санхүүгийн албаны дарга нарт хариуцуулсан ч театрын удирдлагууд ажлаас чөлөөлөгдөж, төрийн аудитын шийдвэр эзэнгүйдсэн;
- Тайлант оны санхүүгийн тайлангийн аудит дуусч аудитын үр дүнг хэлэлцэх үед санхүүгийн албаны даргыг ажлаас чөлөөлж, шинэ томилогдсон ажилтан аудитын залруулгыг хүлээж аваагүйгээс цахим системд тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй байгааг тус тус анхаарах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,472.8 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулаагүй.

Залруулаагүй алдаа:

1. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх 999.1 мянган төгрөгийн илүү төлөлтийг Санхүүгийн байдлын тайланд 473.7 мянган төгрөгийн өглөгөөр тайлагнаж, 1,472.8 мянган төгрөгийн зардлыг илүү тайлагнасан нь УССНББОУС 25.13-т "Ажилтан тайлант үеийн туршид байгууллагад үйлчилгээ үзүүлсэн үед байгууллага нь энэ үйлчилгээний солилцоонд төлөхөөр хүлээгдэж буй ажилтны богино хугацааны тэтгэмжийн дискаунтчилаагүй дүнг хүлээн зөвшөөрнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй тус тус нийцээгүй, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангаагүй;

Аудитаар нийт 222,505.3 мянган төгрөгийн 9 зөрчил илэрсэнд 21,092.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 201,413.3 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 223,978.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон 91,436.9 мянган төгрөгийн материаллаг байдлаас давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Театрын барилга байгууламжийн дэлгэрэнгүй бүртгэлд 80.64 м² талбайн бүртгэлтэй цайны газрыг иргэнтэй 2024 оны 10 дугаар сард хийсэн түрээсийн гэрээнд 34 м² талбайг сарын 1,500.0 мянган төгрөг, нийт 21,000.0 мянган төгрөгөөр түрээслэсэн бөгөөд түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулаагүй, нийт түрээсийн гэрээний үнийн 40.0 хувь буюу 8,400.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй, санхүүгийн үр дүнгийн тайланд 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарыг дуусталх хугацааны түрээсийн орлогыг 4,500.0 мянган төгрөгийг төгрөгөөр дутуу тайлагнаж, дутуу төлбөрийг авлагаар тайлагнаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", Монгол улсын засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын 17-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-т "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын 40 хувиар тогтоосугай" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлээгүй 8,400.0 мянган төгрөг, түрээсийн гэрээний дутуу төлбөр 4,500.0 мянган төгрөг, нийт 12,900.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.1.2. Фотосэт ХХК-аас хэвлүүлж авсан 3,500 ширхэг тасалбар, брошур, урилга, нийт 7,256.0 мянган төгрөгийн үнэт цаас, нярваас тайлант оны 4-р сард тасалбар түгээгчид олгосон тасалбар шаардах хуудас, зарлагын баримттай 300 ширхэг буюу 201.0 мянган төгрөг, нийт 7,457.0 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий орлогыг тайлагнаагүй. Кассын тасалбарын орлогыг хувийн дансаар авдаг, орлогыг цаг тухайд нь төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй, хэвлэлийн компаниар тасалбарыг хэвлэмэл дугаар, үнийн ангилалтай хэвлүүлээгүй, тасалбарын орлогыг тухай бүр төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлдэггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Данс бүртгэлд орлогоор тайлагнаагүй тасалбарын үнэ 7,457.0 мянган төгрөгийг хариуцсан ажилтнаар нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.1.3. Нярваас тасалбар борлуулахаар маркетингийн 2 ажилтан шаардах хуудсаар авсан 27 ширхэг тасалбарын борлуулалтын орлого 735.0 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тасалбарын борлуулалтын орлогын 735.0 мянган төгрөгийг маркетингийн менежер нэр бүхий 2 ажилтнаар нөхөн төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5.2 Албан шаардлага

5.2.1 Нэр бүхий байгууллагуудтай тайз түрээсийн гэрээ болон тоглолт хамтран зохион байгуулах гэрээ байгуулж, гэрээний үлдэгдэл төлбөр нийт 38,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагаар тайлагнаагүй. Тоглолт хамтран зохион байгуулахдаа оролцож байгаа уран бүтээлчдийн тариф байхгүй, тайз түрээсийн гэрээнд ашиглах цагийг тодорхой заагаагүйгээс баталсан тарифыг зөв мөрдөж ажилласан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдоогүй

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тайз, үзэгчдийн танхим түрээслэх, угтах үйлчилгээ үзүүлсэн гэрээний орлогыг дутуу тайлагнаж, үлдэгдэл төлбөрийг авлагаар бүртгээгүй, тооцоо нийлээгүй зөрчлийг таслан зогсоох шаардлага хүргүүлсэн.

5.2.2 Цалингийн тооцооллыг түүвэрлэн шалгахад 6 дугаар сард 2 ажилтны сахилгын шийтгэлийг суутган тооцоогүй 762.5 мянган төгрөг, алба хаасан хугацааны нэмэгдлийг 74.0 мянган төгрөгөөр тус тус илүү, илүү цаг болон нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг 1,418.9 мянга төгрөгөөр дутуу тооцож олгосон. Мөн тайлант оны 4 дүгээр сард байгууллагын дотоод хяналтаар ээлжийн амралтын тооцооллыг буруу хийснээс 8,152.0 мянган төгрөгийг илүү, ажил олгогчийн Хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмжийн 2,067.6 мянган төгрөгийг дутуу олгосон зөрчлүүдийг арилгах завсрын аудитын 5,102.0 мянган төгрөгийн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тухайн үеийн цалингийн нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдсөн тул цаашид цалин хөлсний тооцооллыг холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрийг үндэслэхгүй илүү дутуу тооцож олгодог зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

5.2.3 Санхүүгийн тайланд 138,188.7 мянган төгрөгийн авлага, 19,722.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай тус тус нийцээгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.4 Аудит хийх хугацаанд шалгагдагч байгууллага 2025 оны жилийн эцсийн тооллого хийсэн баримт ирүүлээгүй. Захирлын 2025 оны “Байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах тухай” А/83 дугаар тушаалаар байгууллагын эд хөрөнгийн тооллого хийж, 2025 оны 12 сарын 30-ны өдрийн дотор үр дүнг танилцуулахыг Өмч хамгаалах зөвлөлийн даргад үүрэг болгосон боловч тооллого хийсэн эсэх нь тодорхойгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө, бараа материалын үлдэгдэл үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна”, 72 дугаар зүйлийн 72.4.1-т “Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах” гэж заасантай тус тус нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Өмч хамгаалах зөвлөлийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.5 Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 43002/0055 нэгж талбарын дугаартай 5,934 м.кв, 192,142.9 мянган төгрөгийн бүртгэлийн үнэтэй газрын 2021 оны 746.7 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүйн улмаас Улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлж Э дугаар аваагүй, цахим бүртгэлд хамрагдаагүй, Амгаланд байршилтай бүртгэлийн үнэ 26,869.7 мянган төгрөгийн газрын гэрчилгээг шинэчилж авахаар хүсэлт өгөхөд тус газрыг тойруулан хувь хүмүүс газар авсан шалтгаанаар шинэчилж олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны төсөв захирагчид хүсэлт тавьж газрын төлбөрийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын гэрчилгээг сунгуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайланг СС-ын 2025 оны А/03 тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягтад бүрэн нийцүүлээгүй, Тодруулга 1А, 1Б, 1В, 2, 3, 4, 9, 10, 11, 12, 13-р дутуу байна. Байгууллагын гүйцэтгэлийн тайланд үр дүнг хувиар илэрхийлсэн ч төсөвтэй уялдуулж дүнгээр зэрэгцүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид холбогдох журмыг мөрдөж, батлагдсан маягтын дагуу санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнах.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд өгсөн дээрх 5 албан шаардлага, 3 зөвлөмжийн биелэлт болон Нийцлийн аудитын асуудлаар хүргүүлсэн 2 албан шаардлага, 2 зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Дд | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|----|--|------------|---------|-----------------------------------|-----|--------------------------|---------|------------|-----|--------------|---------|---------|---------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх 999.1 мянган төгрөгийн илүү төлөлтийг Санхүүгийн байдлын тайланд 473.7 мянган төгрөгийн өглөгөөр тайлагнасан | 1 | 1,472.8 | | | 1 | 1,472.8 | | | 1 | 1,472.8 | 1 | 1,472.8 |
| | Дүн | 1 | 1,472.8 | - | - | 1 | 1,472.8 | - | - | 1 | 1,472.8 | 1 | 1,472.8 |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Дд | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал | |
|----|--|-------------|----------|---------------|----------|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|-----|--|-----|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Тоо | Дүн |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| 1 | Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайланг СС-ын 2025 оны А/03 тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн маягтад бүрэн нийцүүлээгүй, Тодруулга 1А, 1Б, 1В, 2, 3, 4, 9, 10, 11, 12, 13-р дутуу байна. Байгууллагын гүйцэтгэлийн тайланд үр дүнг хувиар илэрхийлсэн ч төсөвтэй уялдуулж дүнгээр зэрэгцүүлээгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 2 | Тус байгууллагын барилга байгууламжийн дэлгэрэнгүй бүртгэлд 80.64 м2 талбайн бүртгэлтэй цайны газрыг иргэнтэй 2024 оны 10 дугаар сард хийсэн түрээсийн гэрээнд 34 м2 талбайг сарын 1,500.0 мянган төгрөгөөр буюу нийт 21,000.0 мянган төгрөгөөр түрээслэсэн бөгөөд түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулаагүй, нийт түрээсийн гэрээний үнэ 21,000.0 мянган төгрөгөөс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт | 1 | 12,900.0 | 1 | 12,900.0 | | | | | | | | |

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|--|---|----------|---|---------|----------|--|--|--|--|--|--|
| | 8,400.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй, санхүүгийн үр дүнгийн тайланд 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарыг дуусталх хугацааны түрээсийн орлогыг 4,500.0 мянган төгрөгийг төгрөгөөр дутуу тайлагнаж, дутуу төлбөрийг авлагаар тайлагнаагүй. | | | | | | | | | | | |
| 3 | Фотосэт ХХК-иас хэвлүүлж авсан 3,500 ширхэг тасалбар, брошур, урилга, нийт 7,256.0 мянган төгрөгийн үнэт цаас, нярваас тайлант оны 4-р сард тасалбар түгээгчид олгосон тасалбар шаардах хуудас, зарлагын баримттай 300 ширхэг буюу 201.0 мянган төгрөг, нийт 7,457.0 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тасалбарын орлогыг тайлагнаагүй. Кассын орлогыг хувийн дансаар авдаг, хэвлэлийн компанитай тасалбарыг хүлээн авч тухай бүр акт үйлддэггүй, тасалбарыг хэвлэмэл дугаар, үнийн ангилалтай хэвлүүлдэггүй, тасалбарын орлогыг тухай бүр төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлдэггүй байна. | 1 | 7,457.0 | 1 | 7,457.0 | | | | | | | |
| 4 | Нярваас тасалбар борлуулахаар маркетингийн 2 ажилтан шаардах хуудсаар авсан 27 ширхэг тасалбарын борлуулалтын орлого 735.0 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн. | 1 | 735.0 | 1 | 735.0 | | | | | | | |
| 5 | Нэр бүхий байгууллагуудтай тайз түрээсийн гэрээ болон тоглолт хамтран зохион байгуулах гэрээ байгуулж, гэрээний үлдэгдэл төлбөр нийт 38,000.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагаар тайлагнаагүй. Тоглолт хамтран зохион байгуулахдаа оролцож байгаа уран бүтээлчдийн тариф байхгүй, тайз түрээсийн гэрээнд ашиглах цагийг тодорхой заагаагүйгээс баталсан | 1 | 38,000.0 | | 1 | 38,000.0 | | | | | | |

Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|-----------|--|--|---|-----------|--|--|--|--|--|
| | тарифыг зөв мөрдөж ажилласан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдоогүй. | | | | | | | | | | | |
| 6 | Цалингийн тооцооллыг түүвэрлэн шалгахад 6-р сард 2 ажилтны сахилгын шийтгэлийг суутган тооцоогүй 762.5 мянган төгрөг, алба хаасан хугацааны нэмэгдлийг 74.0 мянган төгрөгөөр тус тус илүү, илүү цаг болон нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг 1,418.9 мянга төгрөгөөр дутуу тооцож олгосон. Мөн тайлант оны 4-р сард Дотоод хяналтаар ээлжийн амралтын тооцооллыг буруу хийснээс 8,152.0 мянган төгрөгийг илүү, ажил олгогчийн Хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмжийн 2,067.6 мянган төгрөгийг дутуу олгосон зөрчлүүдийг арилгах завсрын аудитын зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар хэрэгжүүлээгүй. | 1 | 5,502.0 | | | 1 | 5,502.0 | | | | | |
| 7 | Санхүүгийн тайланд 138,188.7 мянган төгрөгийн авлага, 19,722.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 1 | 157,911.3 | | | 1 | 157,911.3 | | | | | |
| 8 | Аудит хийх хугацаанд шалгагдагч байгууллага 2025 оны жилийн эцсийн тооллого хийсэн баримт ирүүлээгүй. Захирлын 2025 оны “Байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах тухай” А/83 дугаар тушаалаар байгууллагын эд хөрөнгийн тооллого хийж, 2025 оны 12 сарын 30-ны өдрийн дотор үр дүнг танилцуулахыг Өмч хамгаалах зөвлөлийн даргад үүрэг болгосон боловч тооллого хийсэн эсэх нь тодорхойгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө, бараа материалын үлдэгдэл үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | |
| 9 | Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 43002/0055 нэгж талбарын дугаартай 5,934 м.кв, 192,142.9 мянган | 1 | - | | | 1 | - | | | | | |

**Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | | | | | | | | | | |
|--|----------|------------------|----------|-----------------|----------|------------------|----------|---|---|---|---|---|
| төгрөгийн бүртгэлийн үнэтэй газрын 2021 оны 746.7 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүйн улмаас Улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлж Э дугаар аваагүй, цахим бүртгэлд хамрагдаагүй, Амгаланд байршилтай бүртгэлийн үнэ 26,869.7 мянган төгрөгийн газрын гэрчилгээг шинэчилж авахаар хүсэлт өгөхөд тус газрыг тойруулан хувь хүмүүс газар авсан шалтгаанаар шинэчилж олгоогүй байна. | | | | | | | | | | | | |
| Дүн | 9 | 222,505.3 | 3 | 21,092.0 | 5 | 201,413.3 | 1 | - | - | - | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Дд | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|-------------|-----------|---------------|-----|-----------------|-----------|---------|-----|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| 1 | Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан байхгүй. Тендер зарлаагүй, гэрээ байгуулахдаа харьцуулсан судалгаа шинжилгээ хийлгүй нийт 54 аж ахуй нэгж, иргэнтэй 527,948.6 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс гэрээ дүгнэсэн актгүй 46,824.0 мянган төгрөгийн 8 гэрээ байна. | 1 | 527,948.6 | | | 1 | 527,948.6 | | |
| Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| 2 | Дуурь бүжгийн эрдмийн театр нь нийт батлагдсан орон тоо 285, үүнээс тайлант жилд сул орон тоо 13 байна. Сул орон тоог тооцож Монгол Улсын Их Хурлын 2025 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”-д “Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж заасны дагуу 9 хувийн цомхотгол зохион байгуулаагүй. Зарим ажиллагсдын цалин хөлсийг тогтоохдоо төрийн үйлчилгээний ажилтнуудын цалингийн сүлжээнд нийцүүлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| 3 | Тус байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 165 мэдээллээс Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал /Гүйцэтгэл/, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, | 1 | - | | | 1 | - | | |

**Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

| | | | | | | | | | |
|--|---|----------|------------------|--|--|----------|------------------|----------|----------|
| | <p>гүйцэтгэл–Хөтөлбөр, зориулалт /Гүйцэтгэл/ зэрэг 2 мэдээг хугацаа хоцроон байршуулсан. Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын ажил гүйлгээ 1 удаагийн 8,591.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн хаяг талбарт 11 удаагийн 43,200.0 мянган төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт талбарт бүтцийн задаргааг оруулаагүй 1-4 сардуудад "оруулах мэдээлэл байхгүй" гэж мэдээлсэн, тайлант хугацаанд байгууллагын дарга нь иргэн хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой "Ашиг сонирхлын мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй, тайлант онд хөрөнгө мөнгө захиран зарцуулсан 3 удаагийн 47,595.0 мянган төгрөгийн тушаал, гэрээг мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 83.1 хувьтай байна. Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй.</p> | | | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| 4 | <p>Тус театр нь Захирлын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрддөг. Өнгөрсөн хугацаанд холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусган сайжруулаагүй, санхүүгийн ажилтнууд ойр ойрхон солигдсонтой холбоотой бүртгэлийн дотоод хяналт сул. Театрын онцлог бүртгэл үзвэрийн тасалбар, уран бүтээлийн хөрөнгө, урын сангийн бүртгэлүүдийг зөв ангилаагүй, зориулалтын дагуу бүртгээгүй байна.</p> | 1 | - | | | | 1 | | - |
| Дүн | | 4 | 527,948.6 | | | 2 | 527,948.6 | 2 | - |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 65/A0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/82/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Фотосэт ХХК-аас хэвлүүлж авсан 3,500 ширхэг тасалбар, брошур, урилга, нийт 7,256,000.00 /долоон сая хоёр зуун тавин зургаан мянган/ төгрөгийн үнэт цаас, нярваас тайлант оны 4-р сард тасалбар түгээгчид олгосон тасалбар шаардах хуудас, зарлагын баримттай 300 ширхэг буюу 201,000.00 /хоёр зуун нэг мянган/ төгрөг, нийт 7,457,000.00 /долоон сая дөрвөн зуун тавин долоон мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий тасалбарын орлогыг тайлагнаагүй. Кассын орлогыг хувийн дансаар авдаг, хэвлэлийн компанитай тасалбарыг хүлээн авч тухай бүр акт үйлддэггүй, тасалбарыг хэвлэмэл дугаар, үнийн ангилалтай хэвлүүлдэггүй, тасалбарын орлогыг тухай бүр төрийн сангийн дансанд бүрэн төвлөрүүлдэггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4 "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй, гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Данс бүртгэлд орлогоор тайлагнаагүй тасалбарын үнэ 7,457,000.00 /долоон сая дөрвөн зуун тавин долоон мянган/ төгрөгийг бараа материалын нярваар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 66/А015 0122

Улаанбаатар хот

САГ - 2026/82/НА - СТА - ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын барилга байгууламжийн дэлгэрэнгүй бүртгэлд 80.64 м² талбайн бүртгэлтэй цайны газрыг иргэнтэй 2024 оны 10 дугаар сард хийсэн түрээсийн гэрээнд 34 м² талбайг сарын 1,500,000.0 /нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр буюу нийт 21,000,000.0 /хорин нэгэн сая/ төгрөгөөр түрээслэсэн бөгөөд түрээсийн гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраар батлуулаагүй, нийт түрээсийн гэрээний үнэ 21,000,000.0 /хорин нэгэн сая/ төгрөгөөс Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 8,400,000.00 /найман сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг төвлөрүүлээгүй, санхүүгийн үр дүнгийн тайланд 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарыг дуусталх хугацааны түрээсийн орлогыг 4,500,000.00 /дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгөөр дутуу тайлагнаж, дутуу төлбөрийг авлагаар тайлагнаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", Монгол улсын Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын 17-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна. Улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх түрээсийн төлбөрийн хувь, хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тогтооно", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-т "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын 40 хувиар тогтоосугай" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтоох", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.2 "төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлээгүй 12,900,000.00 /арван хоёр сая есөн зуун мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 67/A0150122

Улаанбаатар хот

САГ - 2026 /82/НА - СТА - ТИЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нярваас тасалбар борлуулахаар маркетингийн 2 ажилтан шаардах хуудсаар авсан 27 ширхэг тасалбарын борлуулалтын орлого 735,000.00 /долоон зуун гучин таван мянган/ төгрөгийг төрийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.4-т "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тасалбарын борлуулалтын орлогын 735,000.00 /долоон зуун гучин таван мянган/ төгрөгийг маркетингийн менежер Э.Дэлгэрмаа, Ү.Жаргал нараар нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 330/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/82/НА - СТА - ПШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбартай холбоотой 2 мэдээг хугацаа хоцроон байршуулсан. Цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын ажил гүйлгээ 1 удаагийн 8,591,000.00 /найман сая таван зуун ерэн нэгэн мянган/ төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн хаяг талбарт 11 удаагийн 43,200,000.00 /дөчин гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт талбарт бүтцийн задаргааг оруулаагүй 1-4 сардуудад "оруулах мэдээлэл байхгүй" гэж мэдээлсэн, тайлант хугацаанд байгууллагын дарга нь иргэн хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой "Ашиг сонирхлын мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй, тайлант онд хөрөнгө мөнгө захиран зарцуулсан 3 удаагийн 47,595,000.00 /дөчин долоон сая таван зуун ерэн таван мянга/ төгрөгийн тушаал, гэрээг мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 83.1 хувьтай байна. Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих мэдээллийг мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлдэг, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 331/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий байгууллагуудтай тайз түрээсийн гэрээ болон тоглолт хамтран зохион байгуулах гэрээ байгуулж, гэрээний үлдэгдэл төлбөр нийт 38,000,000.00 /гучин найман сая/ төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагаар тайлагнаагүй. Тоглолт хамтран зохион байгуулахдаа оролцож байгаа уран бүтээлчдийн тариф байхгүй, тайз түрээсийн гэрээнд ашиглах цагийг тодорхой заагаагүйгээс баталсан тарифыг мөрдөж ажилласан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдоогүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайз, үзэгчдийн танхим түрээслэх, утгах үйлчилгээ үзүүлсэн гэрээний орлогыг дутуу тайлагнасан, үлдэгдэл төлбөрийг авлагаар бүртгэдэггүй, тооцоо нийлдэггүй зөрчлүүдийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 332/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/82/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудит хийх хугацаанд шалгагдагч байгууллага 2025 оны жилийн эцсийн тооллого хийсэн баримт ирүүлээгүй. Захирлын 2025 оны "Байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах тухай" А/83 дугаар тушаалаар байгууллагын эд хөрөнгийн тооллого хийж, 2025 оны 12 сарын 30-ны өдрийн дотор үр дүнг танилцуулахыг Өмч хамгаалах зөвлөлийн даргад үүрэг болгосон боловч тооллого хийсэн эсэх нь тодорхойгүй тул жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө, бараа материалын үлдэгдэл үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь тооллого эхлэхээс өмнө өмч хамгаалалтад хяналт тавих үүрэг бүхий болон холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан Тооллогын комисс томилж байгуулна", 72 дугаар зүйлийн 72.4.1-т "Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмч хамгаалах зөвлөлийн хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 333/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/82/НА - СТА - ПИЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд 138,188,677.00 /нэг зуун гучин найман сая нэг зуун наян найман мянган зургаан зуун далан долоо/ төгрөгийн авлага, 19,722,582.72 /арван есөн сая долоон зуун хорин хоёр мянга таван зуун наян хоёр төгрөг далан хоёр мөнгө/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 334/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлаагүй, төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан байхгүй. Тендер зарлаагүй, гэрээ байгуулахдаа харьцуулсан судалгаа шинжилгээ хийлгүй нийт 54 аж ахуй нэгж, иргэнтэй 527,948,640.00 /таван зуун хорин долоон сая есөн зуун дөчин найман мянга зургаан зуун дөчин/ төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна. Үүнээс гэрээ дүгнэсэн актгүй 46,824,000.00 /дөчин зургаан сая найман зуун хорин дөрвөн мянган/ төгрөгийн 8 гэрээ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 46 дугаар зүйлийн 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулаагүй, тендер зарлаагүй шууд гэрээ байгуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 335/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/82/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн тооцооллыг түүвэрлэн шалгахад 6-р сард 2 ажилтны сахилгын шийтгэлийг суутган тооцоогүй 762,500.00 /долоон зуун жаран таван мянган/ төгрөг, алба хаасан хугацааны нэмэгдлийг 74,043.50 /далан дөрвөн мянга дөчин гурван төгрөг тавин мөнгө/ төгрөгөөр тус тус илүү, илүү цаг болон нийтээр амрах баярын өдөр ажилласны нэмэгдэл хөлсийг 1,418,948.00 /нэг сая дөрвөн зуун арван найман мянга есөн зуун дөчин найм/ төгрөгөөр дутуу тооцож олгосон. Мөн тайлант оны 4-р сард Дотоод хяналтаар ээлжийн амралтын тооцооллыг буруу хийснээс 8,151,998.73 /найман сая нэг зуун тавин нэгэн мянга есөн зуун ерэн найман төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийг илүү, ажил олгогчийн Хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмжийн 2,067,605.00 /хоёр сая жаран долоон мянган зургаан зуун таван/ төгрөгийг дутуу олгосон зөрчлүүдийг арилгах завсрын аудитын зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллагаагүй, цалин хөлсний тооцооллыг холбогдох хууль, дүрэм, тушаал шийдвэрийг үндэслэхгүй илүү дутуу тооцож олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 336/АД150122

Улаанбаатар хот

САГ - 2026/82/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дуурь бүжгийн эрдмийн театрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй 43002/0055 нэгж талбарын дугаартай 5,934 м.кв, 192,142,920 /нэг зуун ерэн хоёр сая нэг зуун дөчин хоёр мянга есэн зуун хорь төгрөгийн бүртгэлийн үнэтэй газрын 2021 оны 746,676 /долоон зуун дөчин зургаан мянга зургаан зуун далан зургаан/ төгрөгийн төлбөр төлөгдөөгүйн улмаас Улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлж Э дугаар аваагүй, цахим бүртгэлд хамрагдаагүй, Амгаланд байршилтай бүртгэлийн үнэ 26,869,716.11 /хорин зургаан сая найман зуун жаран есэн мянга долоон зуун арван зургаан төгрөг арван нэгэн мөнгө/ төгрөгийн газрын гэрчилгээг шинэчилж авахаар хүсэлт өгөхөд тус газрыг тойруулан хувь хүмүүс газар авсан шалтгаанаар шинэчилж олгоогүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээд шатны төсөв захирагчид хүсэлт тавьж газрын төлбөрийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Газрын гэрчилгээг сунгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дуурь бүжгийн эрдмийн театрын Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч /М.Энхжаргал/, Ерөнхий нягтлан бодогч /О.Отгонгэрэл/ нар т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ДЭЛГЭРМАА